



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

“Солид Юнити Аудит” ХХК-д даатгалын байгууллагад аудит хийх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 7 дугаар хавсралт “Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн аудитор тавигдах нөхцөл, шаардлага”-ын 2.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Солид Юнити Аудит” ХХК-д даатгалын байгууллагад аудит хийх эрх олгосугай.

2. Аудитын үйл ажиллагааны стандарт, хууль тогтоомжийн дагуу чанарын хяналтыг байгууллагад хэрэгжүүлж ажиллах, чанарын хяналт шалгалтын үнэлгээг тухай бүр тус Хороонд ирүүлэх, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “Солид Юнити Аудит” ХХК (Э.Мөнхтогтох)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН